**ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН СҮХБААТАРЫН ОРХОНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025.06.25

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 1:*** *“Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах; | - | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Тайлант хугацаанд “Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилт болон Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2 тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2 тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 14 тушаал, аймгийн Засаг даргын 5 захирамж зэрэг нийт 23 шийдвэрийг хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Энэхүү шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэл, албан даалгаврыг нийт байцаагч, мэргэжилтэн, ажилтнуудад тухай бүр танилцуулж мэдээллийг хүргэж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тухайлбал, Засгийн газрын 2024 оны 75 дугаар тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгож | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгаа бүх төрлийн тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр авагч 18200 хүний авч байгаа тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлж олгон, нэмэгдлийг тэтгэвэр тогтоолтын хуудаст тэмдэглэл хийн баталгаажуулав. Тус газрын дэргэдэх “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл”д тайлант хугацаанд нийт 28 даатгуулагч өргөдөл ирүүлсэн бөгөөд зөвлөлийг 4 удаа хуралдуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Шийдвэр хүргүүлэх тухай” 2024 оны 04/460 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийг баримтлан 16 даатгуулагчийн хүсэлтийг бүрэн шийдвэрлэн тогтоол гаргаж, 3 даатгуулагчийн асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлж, 9 даатгуулагчийн хүсэлт баримт бичгээр нотлогдохгүйг үндэслэн шийдвэрлэх боломжгүй талаар албан бичгээр хариу хүргүүлж ажиллав. МХШЗ-өөр шийдвэрлэсэн асуудлын 22 нь буюу 78.5 хувь нь малчнаар ажиллаж шимтгэл төлсөн хугацааг тооцуулах, 1 буюу 3.7 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, 5 нь буюу 17.8 хувь нь хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох асуудлууд тус тус ээлж байна. | |
| 1.2. | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын | Тухайн аймаг, дүүргийн ҮА-ны зардлын төсөв | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг зарцуулсан байна. | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 2,121.2 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | НДЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан тус газрын үйл ажиллагааны урсгал зардлын төсөв 2.2 тэрбум төгрөг бөгөөд тайлант хугацаанд 999.9 сая | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах; | | | | | төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч батлагдсан төсвийн хуваарь, зардлын ангиллын дагуу 100% зарцуулж, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатган өр үүсгэлгүй ажиллав. Мөн батлагдсан бүтэц орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хүний нөөц болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр, бусад өр үүсгэлгүй зардал, ангиллын дагуу зарцуулан төсвийн сахилга, хариуцлагыг чанд мөрдөн ажиллалаа. Тайлант хугацаанд хөрөнгө оруулалт, урсгал засварын зардал батлагдаагүй бөгөөд зөвшөөрөгдөөгүй хөрөнгө бэлтгээгүй болно. | |
| 1.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах; | - | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна. | Тус газар нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлөвлөгөө батлах тухай” 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Сургалт зохион байгуулах, төсвийн хуваарийг батлах тухай” 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/74 дүгээр тушаал, “Чиглэл хүргүүлэх тухай” 2025 оны 01/721 дүгээр албан бичгийн дагуу “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт”-ыг зохион байгуулах, “мэргэжлийн сургалтын байгууллага”-ыг сонгон шалгаруулах зорилгоор газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/16 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Энэхүү сургалтыг зохион байгуулах сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан нээлттэй зарласан, одоогийн байдлаар Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны “Хөдөлмөр” сургалт, судалгааны төвөөс сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлтээ ирүүлсэн байна. Сургалтыг 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн болно. | |
| 1.4. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | - | 2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна. | - | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна. | Тус газар нь ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас шударга байдлын үнэлгээ тогтоох, сэтгэл ханамжийн судалгаа авах 5 асуулт бүхий санал асуулгыг цахим орчинд байршуулж иргэд, даатгуулагч санал өгөх нөхцлийг бүрдүүлэн ажиллав.<br><br><br>Энэ арга хэмжээний хүрээнд google forms программ ашиглан шударга байдлын талаар 5 асуулт бүхий санал асуулгад 119 даатгуулагчийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>4.Нийгмийн даатгалын газраас албан хаагчдад ямар чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах хэрэгцээ шаардлагатай байгаа талаар саналаа бичнэ үү;<br>23 responses<br>Нийгмийн даатгалын шинэчилсэн хууль, шинэ программын талаар сургалт<br>Шинэ системийн программ хангамжийн сургалт мэдээлэл<br>танхим болон цахимын сургалт төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалт<br>шинэ программ sicos-ын сургалт авмаар байна. аймгийн зарим нэг байцаагч нар байнга загнасан хаштачсан хандлагатай харилцдаг. хөдөө сумандаа уулзалгүй шууд аймаг яваад уулзана гээд явчихсан хүмүүс байдаг. Тэгэхэд учрыг нь ч ойлгохгүй аймаг явууллаа гэж загнадаг.<br>Хуулийн сургалт<br>Ёсзүйн сургалт танхимаар мэргэжлийн сэтгэлзүйчээс авах<br>Харилцааны соёл<br>Шинэ хууль тогтоомж<br>танхитийн сургалтанд хамрагдмаар бна<br>Сумын байцаагчийн праграм ашиглалт<br>одоо шинэ системийн дэлгэрэнгүй сургалтыг орон нутгийн байцаагчдад<br>Харилцаа, хандлага<br>Хувь хүний хөгжил<br>Танхимаар сургалт авах<br>Шинэ siscos программ сургалт авах<br>Shine cosc sistemin<br>Харилцаа хандлага, эрүүл мэндийн чиглэлээр<br>Нийгмийн даатгалын ажилтны зүгээс даатгуулагчдад ажлын байрны дарамт үзүүлдэг эсэх, шан харамж авах сэдэл төрүүлдэг эсэхэд үнэлгээ авахад санал асуулгад оролцсон иргэдийн 92 хувь нь ямар нэгэн дарамт, сэдэл байхгүй, 8 хувь нь тодорхой хэмжээний сэтгэл зүйн дарамт учруулж байсан гэж хариулсан байна. Мөн google forms порграмм ашиглан дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх, сэтгэл ханамжийн судалгаа авах зорилгоор 5 асуулт бүхий санал асуулгаар нийт 48 албан хаагчаас үнэлгээ авсан.<br><br><br>Албан хаагчдын 52 хувь нь нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн талаар сургалтад хамрагдах, 31 хувь нь харилцаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хандлага, хувь хүний хөгжил, ёс зүйн чиглэлээр сургалт авах, 17 хувь нь шинээр хэрэгжиж буй бусад салбарын хууль тогтоомжтой холбоотой сургалт авах шаардлагатай байгааг тодорхойлсон байна. | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 2:*** *“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах; | - | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 67,183.4 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн. | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлогыг эхний хагас жилийн байдлаар 38.5 тэрбум төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн. Төвлөрсөн сангийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлж, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрт 80.4 тэрбум, тэтгэмжид 4.5 тэрбум төгрөгийг зарцуулав. Сангийн зарлага 2025 оны эхний хагас жилд 88.4 тэрбум төгрөг батлагдсанаас 85.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 2.9 сая төгрөгөөр төсвийн хэмнэлттэй ажиллав. | 100 |
| 2.2. | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | - | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.<br>б) Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн | а)Ажил олгогчийн 29.6 тэрбум, сайн дурын даатгалын төлсөн 2.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого, акт, алдангийг sicos системд таниулан бүртгэлжүүлж ажил олгогч даатгуулагчийн лавлагаа, тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэв.<br>б)Тэтгэврийн сангаас олгосон 18513 тэтгэвэр авагчийн 80.4 тэрбум төгрөгийн тэтгэврийг төрлөөр болон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна.<br>в) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна. | банкаар бүртгэж банкны хуулгатай тулган өглөгийг хааж ажиллав.<br>в)Тэтгэмжийн даатгалын сангаас 1547 тэтгэмж авагчид 3.0 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 305 тэтгэмж авагчид олгосон 1.5 тэрбум төгрөгийн тэтгэмжийг даатгуулагч, мөнгө авагчаар бүртгэж банкны хуулгатай тулган өглөгийг хааж ажиллав. | |
| 2.3. | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | - | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в)Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | а)2025 оны батлагдсан төсөв 2,217.7 сая төгрөг бөгөөд тайлант хугацаанд 999.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авснаас 100 хувь зарцуулсан.<br>б)Төсвийн сахилга батыг баримтлан ажилласан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоол хэрэгжсэнтэй холбоотойгоор эхний хагас жилийн байдлаар түлш халаалт 9.0 сая төгрөгийн өглөг, гэрэл цахилгаан 2.2 сая төгрөгийн өглөг тус тус үүссэн, харин авлага үүсгээгүй ажилласан байна.<br>в)Газрын албан хаагчтай холбоотой цалингийн зардалд 851.4 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 106.9 сая төгрөг, нийт 958.3 сая төгрөгийн санхүүжилт авч 958.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар газрын албан хаагчтай холбоотой цалингийн болон нийгмийн даатгалын шимтгэл, татвар, бусад өр авлагагүй ажиллав._ | 100 |
| 2.4. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн | - | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан | 2024 оны болон 2025 оны 1 дүгээр улирлын сангийн болон үйл ажиллагааны тайланг үнэн зөв | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Мөн сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээг 12 удаа гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын холбогдох мэргэжилтэнд тухай бүрт хүргүүлж ажиллав. | |
| 2.5. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | - | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, | 2024 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын үр дүнг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” программд хугацаанд нь мэдээлэн тайлагнаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 108 дугаар албан бичгээр холбогдох баримт бичгийн хамт хүргүүлж ажиллав. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын байгууллагын эзэмшилд байгаа үндсэн хөрөнгөөс актлах, устгах, хөрөнгө шилжүүлэх жагсаалтыг гарган авч дүнг тус газрын “Өмч хамгаалах байнгын комисс”-т хүргүүлж шийдвэрийг Нийгмийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх;<br>-Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг "Төрийн | даатгалын ерөнхий газарт 2025 оны 119 дүгээр албан бичгээр холбогдох баримт бичгийн хамт хүргүүлсэн бөгөөд хагас жилийн байдлаар дээд газраас ямар нэгэн шийдвэр ирээгүй байна. Хөрөнгийн тооллогын ажлын хэсгээс ирүүлсэн актлах хөрөнгийн жагсаалтыг үндэслэн 2025 оны эхний хагас жилд өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж Нийгмийн даатгалын ерөнхий газраас балансаас балансад шилжиж ирсэн 29,400,000 төгрөгийн балансын анхны өртөгтэй, 4,491,666.57 төгрөгийн балансын үлдэх өртөгтэй суудлын автомашин (Toyoto, Land cruiser 200, B4500, 1567УНҮ улсын дугаартай)-ыг үндсэн хөрөнгийн данс бүртгэлээс хасах, актлах асуудлыг зөвлөлөөр хэлэлцэж үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эвдэрч гэмтсэн, сэргээн засварлах, ашиглах боломжгүй, элэгдлийн хугацаа дуусаагүй 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,858,333.25 (Хоёр сая найман зуун тавин найман мянга гурван зуун гучин гурав) төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг, Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг байгуулах" А/39 дүгээр тушаалын дагуу хөрөнгийн тооллого хийсэн ажлын хэсэг, үйл ажиллагааны нягтлан бодогчийн гаргасан үндсэн хөрөнгө актлах жагсаалт, саналыг үндэслэн зөвлөлөөр хэлэлцэж хөрөнгийн тооллогоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем" программд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | дууссан, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн, эвдэрч гэмтсэн, сэргээн засварлах, ашиглах боломжгүй болсон 34,792,566 (Гучин дөрвөн сая долоон зуун ерэн хоёр мянга таван зуун жаран зургаа) төгрөгийн балансын үнэ бүхий 42 нэр төрлийн 86 ширхэг компьютер, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, программ хангамж зэрэг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэгдсэн хөрөнгийг актлах, данс бүртгэлээс хасахаар шийдвэрлэн тус тус дүгнэлт гаргаж ажиллав. Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлийг www.pcsp.gov.mn цахим хуудасны программ хангамжид мэдээллийг бүрэн оруулан ажиллалаа. Тайлант хугацаанд хэлтэс түрээсийн хөрөнгө ашиглалттай холбоотой гэрээ, зардал, хөрөнгө гаргаагүй болно. | |
| 2.6. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажиллах. | - | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авах.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | 2024 оны нийгмийн даатгалын сангийн болон үндсэн үйл ажиллагааны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд Их монгол хөлөг ХХК-иас аудит хийгдэж "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан. Аудитын байгууллагаас 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 7 зөвлөмж тус тус өгөгдсөн. Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.7. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого цуглуулах, тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээ үзүүлэх гэрээг Хаан банкны Төв салбар, Төрийн банк Төв аймаг салбаруудтай байгуулсан. Харилцагч банкуудаар 18200 тэтгэвэр авагч, 1852 тэтгэмж авагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, зөрчилгүй ажилласан бөгөөд НДЕГазар болон банкуудын хамтран ажиллахаар байгуулсан гэрээний биелэлтийг заалт бүрээр нь дүгнэж НДЕГазарт хүргүүлсэн. | 100 |
| 2.8. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | - | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу ажил гүйлгээг аккурэль болон мөнгөн сууриар бүртгэн хөтөлж, бүртгэлийн алдаа гаргахгүй байхад хяналт тавьж, нэр данс зөрүүтэйгээс орлого орж ирэх тухай бүрт залруулга хийн ажилласан. Сумдын байцаагч, мэргэжилтнээс ирүүлсэн анхан шатны баримтыг газрын байцаагч, мэргэжилтнүүд мэдээллийн баазад оруулсны дараа шат дараалан хянаж баталгаажуулсны үндсэн дээр тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг олгож байна. Газрын байцаагч, мэргэжилтнүүд бэлтгэсэн тэтгэвэр, тэтгэмж олгох жагсаалтыг газар, хэлтсийн даргаар хянуулж, баталгаажуулсны үндсэн дээр тэтгэвэр, тэтгэмжийг олгож байна.<br>2025 оны эхний хагас жилийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэлээр 213 ажил олгогч, 299 албан журмын даатгуулагчийг шинээр нийгмийн даатгалд хамруулж, мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн санг бүрдүүлэв. | |
| 2.9. | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | - | Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн Core системд нийгмийн даатгалын 3 банкны 5 сангийн дансны хуулгаар орлого, зарлагын гүйлгээг сар бүр таниулан мэдээллийн санд оруулж сар, улирал, жилийн тайлан мэдээг нэгтгэн гаргаж ажиллав. Нийгмийн даатгалын салбарын мэдээллийн системийн ашиглалтыг иргүүлсэн чиглэл, зааврын дагуу тухай бүрт шуурхай гүйцэтгэн ажиллаж байна. Мөн НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төв, ДАМГазарт мэдээллийн системийг ашиглахад үүсч буй алдаа, хөгжүүлэлт, сайжруулалт системд шинээр оруулах 38 саналыг нэгтгэн хүргүүлж, тодорхой асуудлуудыг шийдвэрлүүлж ажиллалаа. | 100 |
| 2.10. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | - | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн | Үйл ажиллагааны батлагдсан урсгал зардал, бүтэц, орон тооны хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан бөгөөд тайлант хугацаанд өр, авлага үүсгэлгүй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулав. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийн үлдэгдлийг улирал бүрээр тооцоо нийлж баталгаажуулсан бөгөөд сангуудын бусад авлага, өглөгийн бүртгэлийг нягтлах, эзэн холбогдогчтой тооцоо нийлэх, барагдуулах ажлыг хийж гүйцэтгэв. Нийгмийн даатгалын сан болон байгууллагын санхүүгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр нь баталгаажуулан ажилладаг ба баталгаажуулсан тайланг тухай бүрт холбогдох хавсралтын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуваарийн дагуу хүргүүлэв. | |
| 2.11. | Аймаг, сумын хэмжээн дэх ойрын 3 жилийн хугацаанд тэтгэвэрт гарах иргэдийн судалгааг гаргаж, тэтгэвэрт тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийг нягтлан шалгаж, иргэдэд зөвлөн тусалж нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах; | - | Хүн амын судалгаа, түүвэр судалгаа, зөвлөгөө мэдээлэл өгсөн хүний тоо, нийгмийн даатгалын хамралтын хувь | - | Хүн амын судалгааг нарийвчлан гаргаж, баримт бичгийг нягтлан шалгаж зөвлөгөө өгч, тэтгэвэр тогтоолгох насандаа тэтгэвэрт гарах нөхцөлийг хангуулж ажилласан байна. | Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны хүн амын тоо 56.8 мянга байгаа бөгөөд үүнээс өндөр насны тэтгэвэр авагчийн тоо 14.9 мянга байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын тооны 26.2%-ийг эзэлж байна. Тус газрын тэтгэврийн тогтоолт, олголт хариуцсан байцаагч, мэргэжилтэн, сумын байцаагч, мэргэжилтнүүд 27 сумын хэмжээнд ойрын жилүүдэд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсч буй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, энэхүү судалгаанд үндэслэн иргэдийн баримт бичгийг нягтлан шалгаж өдөр тутам зөвлөн тусалж хуульд заасан тэтгэврийн насандаа тэтгэвэрт гарах нөхцлийг бүрдүүлэн нийгмийн баталгааг хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд 12,276 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, зөвлөмжийн хуудас бичиж үйлчилгээ үзүүлсэн болно. | 100 |
| ***Зорилт 2.1:*** *“Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг ниймгийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1.1. | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний | 2024 онд 5493 хүнийг сайн дурын даатгалд, үүнээс 3109 малчин хамруулав. | Сайн дурын даатгалд шинээр 682 хүнийг үүнээс 460 малчныг шинээр хамруулж төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 211 сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | | биелэлтийн хувь | | | хэмжээ зохион байгуулж, үүнд 81 ажил олгогч, 3981 албан журмын даатгуулагч, 3751 сайн дураар даатгуулагч, нийт 7732 иргэд даатгуулагчийг хамруулав. Дээрх арга хэмжээг үе шаттай зохион байгуулсны үр дүнд 2024 онд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоо 5446 байсныг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 4500 буюу өмнөх оны мөн үеэс 280 даатгуулагчаар нэмэгдэж 10.2 хувиар өссөн байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалд сайн дураар 3850 даатгуулагчийг хамруулахаас 4500 даатгуулагчийг хамруулж, шимтгэлийн орлогод 2710.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 116.8 хувиар давуулан биелүүлсэн байна. Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийг төрлөөр нь авч үзбэл:<br>Энгийн-909 (шинээр-116)<br>Малчин-3042 (шинээр-415)<br>Оюутан-135 (шинээр-28)<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх-57 (шинээр-21)<br>0-3 насны хүүхдээ асарч буй эх-357 (шинээр-95) иргэнийг тус тус хамруулллаа. | |
| 2.1.2. | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2024 онд 899 ажил олгогч, 16970 хүнийг албан журмын даатгалд хамруулав. | Ажил олгогчийн тоог шинээр 82, даатгуулагчийн тоог шинээр 492 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Тайлант хугацаанд аймгийн Татварын газраас авсан судалгаагаар нийт бүртгэлтэй 2852 аж ахуйн нэгж, байгууллагаас ногдолтой тайлантай 933 байгууллагыг нийгмийн даатгалд хамруулллаа. Харин ”Х” тайлантай 1639 аж ахуйн нэгж, байгууллага байна. Татварын байгууллагад бүртгэлтэй 213 ажил олгогч, 299 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнийг албан журмын даатгуулагчаар бүртгэн нийгмийн хамгааллыг бүрдүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал ААН-ийн тоо 34, даатгуулагчийн тоо 251-оор тус тус нэмэгдсэн байна. | |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдлээс 70-аас доошгүй хувиар бууруулах; | - | Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 2,097.3 сая төгрөгт хүрсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 1,468.1 сая төгрөгийг /2.1.4-д зааснаас бусад шимтгэлийн авлага/ бүрэн барагдуулах. Шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг "Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил" болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/47 дугаар тушаалын дагуу тус Нийгмийн даатгалын газрын "Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил" урианы жилийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны эхний үлдэгдэл 2.1 тэрбум төгрөг байсан нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 0.7 тэрбум төгрөгт хүргэж, оны эхнээс 248 аж ахуйн нэгж, байгууллагын 1.4 тэрбум төгрөгөөр буюу 66.6 хувиар бууруулж ажиллалаа. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг нэмж үүсэхгүй байхад анхаарч ажиллалаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажлын хүрээнд 5 аж ахуйн нэгж, байгууллагын арилжааны 12 банк дахь дансыг хааж, 7 аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардлага хүргүүлж, 18 байгууллагатай шимтгэлийн авлага барагдуулах уулзалтын тэмдэглэл, 8 байгууллагатай харилцан тохиролцож авлага барагдуулах, хамтран ажиллах гэрээ байгуулж, шимтгэлийн өр авлага барагдуулах мэдэгдэл 33 байгууллагад хүргүүлж, хуримтлагдсан авлагатай аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллаж буй ажилтанд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг хязгаарлах зэрэг арга хэмжээг авч ажиллалаа. | |
| 2.1.4. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх; | - | Шимтгэлийн өргүй гарсан байх. | Төсөвт байгууллагын шимтгэлийн өр 156.9 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 254.4 сая төгрөг байна. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах. | Тайлант хугацаанд төсөвт байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байна. Харин нэг орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нийгмийн даатгалын шимтгэлийн өр 162.0 төгрөгийн үлдэгдэлтэй, 2 аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулж ажиллав. | 100 |
| 2.1.5. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100 % хангуулна. | Нийгмийн даатгалын санд 67,183.4 сая төгрөгийн орлого хуримтлуулав. | Нийгмийн даатгалын санд 71,928.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны эхний хагас жилийн орлогын төлөвлөгөө 33.1 тэрбум төгрөг оруулахаас хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 34.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 104.8 хувиар давуулан биелүүлж, төвлөрсөн сангийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт тухай бүрт төвлөрүүлэн ажиллалаа. | 100 |
| 2.1.6 | Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд хамгааллын газруудтай хамтран ажиллаж, | - | Зохион байгуулсан арга хэмжээ, нийгмийн даатгалын хамралтын хувь | - | Хамтын ажиллагаа, ажлын уялдааг бэхжүүлж нийгмийн даатгалын | Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд хамгааллын газруудтай хамтран ажиллаж сургалт нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх; | | | | хамралтыг нэмэгдүүлсэн байна. | байгуулсны үр дүнд 2024 онд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоо 5446 байсныг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 4500 буюу өмнөх оны мөн үеэс 280 даатгуулагчаар нэмэгдэж 10.2 хувиар өссөн байна. | |
| 2.1.7 | Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, 119 дугаар ангид тус тус хугацаат цэргийн албыг 1995 оноос хойшхи хаасан даатгуулагчдын нийгмийн даатгал шимтгэлийг нөхөн төлүүлэх арга хэмжээг НДЕГазартай хамтран зохион байгуулах; | - | Зохион байгуулсан арга хэмжээ, ажил олгогч, даатгуулагчийн тоо, нөхөн төлсөн шимтгэлийн дүн | - | Нийгмийн даатгалын мэдээллийн санд ороогүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалж ажилласан байна. | Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Зэвсэгт хүчний 016 дугаар анги, нэгтгэл, Зэвсэгт хүчний 119, 150 дугаар цэргийн ангиуд нь 1995-2005 онд хугацаат цэргийн алба хаагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, тайлагнаагүй Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар удаа дараа хандсан боловч хугацаат цэргийн алба хаасан иргэдийн бүртгэл “Батлан хамгаалахын архив”-т байдаг нууцлалтай гэсэн үндэслэлээр асуудлыг шийдвэрлээгүй. Дээрх анги, нэгтгэлүүдтэй хамтран ажиллах, шимтгэлийг нөхөн төлүүлэх, цэргийн анги, нэгтгэлийн холбогдох эрх бүхий дээд шатны байгууллагад асуудлыг уламжлан шийдвэрлүүлэхээр тус газраас 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 149 дүгээр албан бичгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлээд байна. | 100 |
| 2.1.8 | Төв аймагт үйл ажиллагаа явуулж байсан томоохон уул, уурхайн аж ахуйн нэгж, байгууллагуудын 1995 оноос хойшхи хугацаанд ажиллаж байсан даатгуулагчдын | - | Зохион байгуулсан арга хэмжээ, ажил олгогч, даатгуулагчийн тоо, нөхөн төлсөн шимтгэлийн дүн | - | Нийгмийн даатгалын мэдээллийн санд ороогүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлж, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалж | Заамар суманд үйл ажиллагаа явуулж байгаа Монголросцветмет ТӨҮГ-ын “Шижир алт” алтны үйлдвэрээс 1995-1997 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг нөхөн гаргуулах, 1998 оны тайланг ирүүлсэн боловч ажилчдын нэрс, цалингийн бичилт гаргацгүй, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх арга хэмжээг зохион байгуулах; | | | | ажилласан байна. | архивын баримтад тавигдах шаардлагыг хангаагүй зэрэг зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах агуулга бүхий 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 126 дугаар албан бичгийг тус газраас хүргүүлсэн бөгөөд уг байгууллагаас одоогоор хариу ирүүлээгүй байна. | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 3:*** *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих; | - | - Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ. | Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй байна. | Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна**.** | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг тавих журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар газрын фэйсбүүк, байгууллагын фэйж хуудсаар дамжуулан 330 гаруй удаагийн зар, мэдээллийг тухай бүрт иргэд даатгуулагчдад хүргэв. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас https://www.gov.mn/, нээлттэй мэдээллийн нэгдсэн систем буюу http://www.shilen.gov.mn/, tuv.ndaatgal.mn зэрэг газрын цахим хуудсанд Засгийн газрын 143 дугаар тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу мэдээллийг шинэчилж, баяжилтыг хийж ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Түүнчлэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга, үйлчилгээний талаар 14 постер мэдээлэл, 6 төрлийн үйлчилгээний гарын авлага боловсруулан хэвлүүлж нийтдээ 2500 орчим гарын авлага, тараах материал түгээн, сургалт сурталчилгаанд ашигласан байна. Нийгмийн даатгалын 17 төрлийн цахимжсан үйлчилгээ, E Mongolia, Portal.ndaatgal.mn системийг иргэд, даатгуулагчдад сурталчлан таниулсны үр дүнд үйлчилгээг шуурхай хүргэн ажиллаж байна. | |
| 3.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих; | - | - Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна.<br>- Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна. | Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 59 хувьтай байна. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд: Нийгмийн даатгалын сан: 2025 оны 5 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 72 мэдээлэл байршуулахаас 67 мэдээллийг хугацаандаа, хэрэгжилт 100 хувь, хугацаандаа байршуулсан 93 хувь байна.<br>Үйл ажиллагаа: 2025 оны 5 дугаар сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим хуудсанд 72 мэдээлэл байршуулахаас 19 мэдээллийг хугацаа хоцроож, 53 мэдээллийг хугацаандаа, хэрэгжилт 100 хувь, хугацаандаа байршуулсан 73.6 хувь байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 83.3 хувь биелэлттэй байна. | |
| ***Зорилт 3.1:*** *“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1.1. | Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах, | - | - Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь,<br>- Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл,<br>Илэрсэн төлбөр, зөрчлийн баргадуулалтын хувь. | - | Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | 1.Тус газар нь тайлант хугацаанд Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу нийт 171 ажил олгогчид хяналт шалгалт хийхээс 40 ажил олгогчийг шалгалтад хамруулж, нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг илрүүлэн 2 ажил олгогчид 8.6 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулж, зөрчилгүй ажилласан байгууллагуудад хяналт шалгалтын зөвлөмж өгч ажиллав.<br>2.Дотоод хяналт шалгалтын хүрээнд Зуунмод, Аргалант, Борнуур сумдын 2022 оны 374, 2023 оны 366 шинээр тогтоогдсон нийт 740 тэтгэврийн тогтоолтод хяналт шалгалт хийж 258 хувийн хэрэгт зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн хяналт шалгалтаар тушаалын үндэслэл шалгуулах-5, эрх үүсээгүй-5, шүүхээр ажилласан хугацааг тогтоолгох-3, нийт 13 тэтгэвэр авагчийн тэтгэврийг зогсоохоор шийдвэрлэсэн болно. Бусад шалгагдсан тэтгэврийн хувийн хэрэгт зөрчил илрээгүй болно.<br>3.Өргөдөл, гомдол, аж ауйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу 63 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн 27 байгууллагын холбогдох бичиг баримтыг шалгаж нийт 17.8 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулав.<br>4.Шинээр тогтоогдсон болон шилжиж ирсэн 730 тэтгэвэр тогтоолтод хяналт шалгалт хийж 292 тэтгэврийн тооцооллын болон баримт бичгийн зөрчлийг илрүүлэн нөхөн бүрдүүлэлт хийж, баримтын зөрчлийг арилгуулж тэтгэвэр тогтоох, олгох нөхцлийг бүрдүүлж ажиллав.<br>5.Шинээр тогтоогдсон тэтгэмжийн тогтоолтод хяналт шалгалт хийж ажилгүйдэл 245, Жирэмсний болон амаржсаны тэтгэмж 382, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 264, хөдөлмөрийн чадвар алдсаны 358, нийт 1252 тэтгэмжийн тогтоолтыг хянаж, 375 тэтгэмж авагчийн тооцооллын болон тэтгэмж авах эрх үүсээгүй зөрчлийг илрүүлэн зөрчлийг арилгуулж тэтгэмж авах нөхцлийг бүрдүүлж ажиллалаа.<br>6.Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн 2024 оны 8/2461 дугаар албан бичгийн дагуу шалгалт хийж Монгол улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан иргэнд илүү олгосон 10.6 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, Цагдаагийн байгууллагтай хамтран | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласны үр дүнд актын төлбөрийг барагдуулж, санд төвлөрүүллээ.<br>7.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд: Нийгмийн даатгалын сан: 2025 оны 5 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 72 мэдээлэл байршуулахаас 67 мэдээллийг хугацаандаа, хэрэгжилт 100 хувь, хугацаандаа байршуулсан 93 хувь байна.<br>Үйл ажиллагаа: 2025 оны 5 дугаар сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 72 мэдээлэл байршуулахаас 19 мэдээллийг хугацаа хоцроож, 53 мэдээллийг хугацаандаа, хэрэгжилт 100 хувь, хугацаандаа байршуулсан 73.6 хувь байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 83.3 хувь биелэлттэй байна.<br>8.Урьд оны шүүхийн шийдвэртэй 2 ажил олгогчийн 16.5 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж ажиллалаа. | |
| 3.1.2. | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн | - | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02/1270 дугаар албан бичигт дурьдсан хугацаа буюу 10 дугаар сард хяналт шалгалтыг хийхээр ажиллаж байгаа болно. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | | | | хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | | |
| 3.1.3. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | - | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | Тус газар нь тайлант хугацаанд Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу нийт 171 ажил олгогчид хяналт шалгалт хийхээс 40 ажил олгогчийг шалгалтад хамруулж, нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг илрүүлэн 2 ажил олгогчид 12.8 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулж, зөрчилгүй ажилласан байгууллагуудад хяналт шалгалтын зөвлөмж өгч ажиллав. | |
| 3.1.4. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж | - | -Хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь,<br>- НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо, | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т хүргүүлж ажилласан. | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн | **Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас:** нийгмийн даатгалын санд шалгалт хийж тогтоосон улсын байцаагчийн актын үлдэгдэл 5.0 сая төгрөгөөс 0.6 сая төгрөг буюу 1.2 хувийг барагдуулав. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх, | | | | ажлын үр дүнг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | шалгалтын газраас шалгаж тогтоосон хуурамч баримт бичиг бүрдүүлж тэтгэвэр тогтоолгон авсан 14 иргэний 160.5 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж 9 тэтгэвэр авагчдад газрын хяналт шалгалтын байцаагчид 107.6 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож 94.8 сая төгрөгийг барагдуулж ажиллалаа. Дээрх улсын байцаагчийн актын төлбөр зөрчлөөс 2 тэтгэвэр авагчид холбогдох 12.8 сая төгрөгийн үлдэгдлийг тэтгэврээс нь сар бүр суутгал хийж барагдуулахаар ажиллаж байна.<br>**Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:** Нийгмийн халамжийн санд хяналт шалгалт хийж 49 иргэнд илүү олгосон 8.6 сая төгрөгийн тэтгэврийг буцаан төлүүлэх улсын байцаагчийн акт тогтоож 1.6 сая төгрөгийг барагдуулж, улсын байцаагчийн актын биелэлт 18.6 хувьтай байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тэтгэвэр, тэтгэмжийн санд хийгдсэн шалгалтын актын үлдэгдэл 4.5 сая төгрөгийн үлдэгдлээс 1.1 төгрөг, үйлдвэрлэлийн ослын хувь хэмжээ буруу тооцсон 0.2 сая төгрөгийг тус тус барагдуулав. Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийгдэж 64 даатгуулагчид 38.6 сая төгрөг илүү олгосон, 39 даатгуулагчид 23.8 сая төгрөг дутуу олгосон зөрчилд улсын байцаагчийн акт тогтоосныг заасан хугацаанд нь барагдуулахаар ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аудитын газраас 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж: 0.1 сая төгрөгийн акт-1, албан шаардлага-3, зөвлөмж-7 тус тус өгөгдсөн. Актын төлбөр зөрчлийг бүрэн барагдуулж, албан шаардлагын хариуг хугацаанд нь хүргүүлж ажиллав. | |
| 3.1.5. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | - | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах, | Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналт тавьж ажилласан. | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Хяналт шалгалтын тайлан, мэдээг улсын байцаагчийн актад үндэслэн гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлэв. 2025 оны эхний хагас жилийн хяналт шалгалтын тайлангаар урд оны үлдэгдэл 106.0 сая төгрөгийн актын үлдэгдэл дээр шинээр 32.4 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож 52.4 сая төгрөгийг барагдуулж, 86.0 сая төгрөгийн улсын байцаагчийн актын төлбөр зөрчлийн үлдэгдэлтэй байна. | 100 |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 4:*** *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1. | Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | - | - 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.<br>-Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн | 2024 онд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, биелэлтийг нэгтгэн авч, дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 89,4%-тай хэрэгжсэн байна. | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Төв аймгийн Засаг даргын хооронд байгуулсан хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн гэрээний биелэлт, Аймгийн хөгжлийн жилийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөний биелэлт болон бусад ажил үйлчилгээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, цаасан болон цахим хэлбэрээр хугацаанд нь тайлагнан хүргүүллээ. | |
| 4.2. | Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | - | -Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ.<br>-Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин 2024 онд 100%-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна. | Тайлант хугацаанд Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой 5 гомдлыг хүлээн авч шийдвэрлэн иргэн, даатгуулагчид албан бичгээр шийдвэрлэлтийн хариуг хүргүүлэв. Тэтгэмжийн үйлчилгээ цахимжсантай холбоотой ажил олгогчийн нягтлан бодогчоос шимтгэлийн цахим системээр эмнэлгийн хуудсыг ирүүлээгүй асуудлыг нягтлан шалгаж мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 346 албан бичиг, хүсэлтийг хүлээн авснаас 112 хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч, 5 бичгийн шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. Харин 117 өргөдөл гомдол хүлээн авсан бөгөөд 103 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 14 өргөдөл хугацаа болоогүй шийдвэрлэлтийн явцад байна . | 100 |
| 4.3. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх; | - | Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хانган ажилласан. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргах, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр тайлагнасан | Тайлант хугацаанд тус газраас Тэтгэврийн тогтоолт, олголт хариуцсан байцаагч, мэргэжилтэн, Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн, Мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, Баян, Баянцагаан, Дэлгэрхаан сумын байцаагч, мэргэжилтэн зэрэг 6 сул орон тооны захиалгыг Төв аймаг дахь Төрийн албаны салбар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | зөвлөлд албан бичгээр хүргүүлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Баян, Баянцагаан, Дэлгэрхаан сумын байцаагч, мэргэжилтний болон Мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний сул орон тоо тусгай шалгалтаар нөхөгдөөгүй байгаа болно. | |
| 4.4. | Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх; | - | Холбогдох судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. | Цаг хугацаанд нь үнэн зөв гаргах. | Судалгааг үнэн зөв гаргаж холбогдох баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу “Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай” аймгийн Засаг даргын 2025 оны Б/04 дүгээр захирамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 17 байцаагч, мэргэжилтэнд нэмэгдлийг тооцож олгов. Тус газрын байцаагч, мэргэжилтний мэргэшлийн зэргийн нэмэгдэл авах албан хаагчдын судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж, шийдвэрийн дагуу тус газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Б/17 дугаар тушаалаар тэргүүлэх-3, зөвлөх-2, итгэмжит-5, нийт 10 албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тооцож олгож байна. | 100 |
| 4.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу дунд | - | Хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны дэд төлөвлөгөөг | Тайлант хугацаанд газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 17 хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөн батлуулж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах; | | удирдлагын газарт хүргүүлсэн байна. | боловсруулан батлаж, хэрэгжүүлсэн. | баталж, газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | хэрэгжилтийг ханган ажиллав. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан төлөвлөгөө, хэрэгжилтийг тус тус хавсаргав. | |
| 4.6. | Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | | Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна. | Салбарын хэмжээнд 100 хувь ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж холбогдох газарт хүргүүлсэн. | Авлигын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Нийгмийн даатгалын газрын хэмжээнд ХАСХОМ гаргах 25 албан хаагчийн мэдүүлгийг гаргуулан баталгаажуулж, тайлан мэдээг хугацаанд нь Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв. | 100 |
| 4.7. | 2024 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх; | - | Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна. | Улсын байцаагчийн актын төлбөр барагдуулаагүй 2 байгууллагыг шүүгчийн захирамжаар албан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулж, ШШГГазарт шилжүүлж 1.3 сая төгрөгийг санд төлүүлсэн. | Судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлнэ. | Урьд оны шүүхийн шийдвэртэй 2 ажил олгогчийн 16.5 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж ажиллалаа. | 100 |
| 4.8. | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах; | - | -Хугацаанд нь хүргүүлэх,<br>-Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 90%-тай байсан. | Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Төв аймгийн Засаг даргын хооронд байгуулсан хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн гэрээний биелэлт, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 01 тоот албан даалгавар болон бусад ажил үйлчилгээний хэрэгжилтийг цаасан болон цахим хэлбэрээр тайлагнаж, хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. | |
| 4.9. | Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗ,АСЗУСэргийлэх тухай хууль, Ёс зүйн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, шударга байдлын үнэлгээ тогтоох судалгааг авч нэгтгэн, сайжруулах арга хэмжээ авах; | - | Зохион байгуулсан арга хэмжээ, судалгааны тоо мэдээ, гарсан саналын тоо, хуулийн хэрэгжилт 100 хувь | НДЕГазраас баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж “Шударга байдлын үнэлгээг тогтоох” 2 төрлийн судалгааг иргэд, газрын албан хаагчдаас 1 удаа авч нэгтгэн дүгнэлт хийж ажилласан. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг удирдлагын зүгээс хамгаалж ажиллаж байна. Тус газар нь google forms порграмм ашиглан шударга байдлын талаар 5 асуулт бүхий санал асуулгад 119 даатгуулагчийг хамруулсан. Нийгмийн даатгалын ажилтны зүгээс даатгуулагчдад ажлын байрны дарамт үзүүлдэг эсэх, шан харамж авах сэдэл төрүүлдэг эсэхэд үнэлгээ авахад санал асуулгад оролцсон албан хаагчдын 92 хувь нь ямар нэгэн дарамт, сэдэл байхгүй, 8 хувь нь тодорхой хэмжээний сэтгэл зүйн дарамт учруулж байсан гэж хариулсан байна. Тус газар нь google forms порграмм ашиглан дотоод шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 5 асуулт бүхий санал асуулгаар нийт 48 албан хаагчдаас үнэлгээ авсан. Албан хаагчдын 52 хувь нь нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн талаар сургалтад хамрагдах, 31 хувь нь харилцаа хандлага, хувь хүний хөгжил, ёс зүйн чиглэлээр сургалт авах, 17 хувь нь шинээр хэрэгжиж буй бусад салбарын хууль тогтоомжтой холбоотой сургалт авах шаардлагатай байгааг тодорхойлсон байна. | 100 |
| ***Зорилт 4.1:*** *“Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх,* | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1.1. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулах; | - | -Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах,<br>-Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Газрын ажилтнуудад Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Монголын улсын Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр тус тус аймгийн Төрийн байгууллагын албан хаагчдад Төрийн албаны салбар зөвлөлийн уялдаа холбоо, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, гэсэн чиглэлээр сургалт зохион байгуулж, газрын 36 албан хаагчийг хамруулсан. “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт дотоодын сургалтыг 02, 05 дугаар сард газрын нийт 85 байцаагч, ажилтнуудад зохион байгуулж ажиллав. | 100 |
| 4.1.2. | Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | | -Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>-Албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 17 удаагийн сургалтад 255 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулсан. | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд Төрийн албан хаагчийн харилцаа хандлагыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлоос ангид байх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хувь хүний мэдээллийг хамгаалах, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга бат, нэр хүндийг өндөрт өргөх, элдэг найрсгаар түргэн шуурхай нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх чадварыг тасралтгүй сайжруулах чиглэлээр ГБХНХЯам-1, НДЕГ-30, ТАЗ-ийн Төв аймаг дахь салбар зөвлөл-1, Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-1, Прокурорын газар-2, ГБХЗХГазар-3, НДГазар-5, нийт 43 удаагийн цахим, танхим хосолсон сургалтад давхардсан тоогоор 1290 байцаагч, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжилтэн, ажилтныг хамруулан урьдчилан сэргийлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудад дотоодын сургалтыг цахимаар 11 удаа, танхимаар 5 удаа, Нийгмийн даатгалын ерөнхий газраас цахимаар 30 удаа зохион байгуулсан сургалтад байцаагчдыг хамруулж, хуулийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн ажилласан. Тухайлбал 2025 оны 2, 3, 5 дугаар сард 27 сумын 27 байцаагч, мэргэжилтэнд чиглүүлэх сургалтыг зохион байгуулж, нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын талаар албан хаагчдад нэгдсэн ойлголт өгөх, нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсан болно. Тус газраас төрийн албанд шинээр томилогдсон 8 албан хаагчид шинэ албан хаагчийн “Чиглүүлэх болон дасан зохицох хөтөлбөр’’-т хамруулж, ажлын байранд нь мэргэшүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллав. | |
| 4.1.3. | Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | -Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>- 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах,<br>-Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг | Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 154 удаагийн сургалтад 173 аж ахуйн нэгжийн 19970 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулсан. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд | Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 211 удаагийн сургалт, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулж, эдгээр арга хэмжээнд 81 ажил олгогч, 7732 иргэд, даатгуулагчдыг хамруулав. Тухайлбал, “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн арга хэмжээг Борнуур, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамруулсан байна. | | даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна. | Бүрэн, Дэлгэрхаан сумдад,<br><br><br>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас зохион байгуулсан "Иргэдээ сонсоё" өдөрлөг, "Малчдын зөвлөгөөн",<br><br>Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 12-р ангийн сурагчдад зориулсан "Даатгалтай ирээдүй" сэдэвт сургалт зэрэг арга хэмжээг Алтанбулаг, Архуст, Бүрэн, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл сумын 450 гаруй иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, сайн дураар даатгуулахын ач холбогдол, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн үйл ажиллагааны талаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалт зохион байгуулж, мэдээлэл хүргэж ажиллав.<br><br><br><br>Түүнчлэн аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо зэрэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж аж ахуйн нэгж байгууллагуудад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулж хууль тогтоомжийг сурталчлан таниулж ажиллав. Мөн 26 сумын багийн иргэдийн нийтийн 136 удаагийн хуралд оролцож 4080 иргэд, даатгуулагчид, 18 ажил олгогч, байгууллагын 312 албан журмын даатгуулагчийг тус тус хамруулсан байна.    | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Мөн нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээг сурталчилсан 4 видео контент, 14 постер мэдээллийг байгууллагын пэйж хуудсаар дамжуулан түгээж, 6 төрлийн үйлчилгээний гарын авлагыг боловсруулж хэвлүүлэн, 2500 орчим гарын авлага, тараах материалыг түгээн, сургалт сурталчилгаанд ашигласан байна. | |
| ***Зорилт 4.2:*** *“Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах; | - | Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна. | Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан. | Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, олон нийтэд таниулах, сурталчлах “Ногоон-Сэргэлт, Ногоон-Төв аймаг” бүх нийтээр мод тарих сарын аяны хүрээнд “Ланс цэцэрлэгт хүрээлэн”-д хамт олны дэмжлэгээр 15 ширхэг бургас мод тарьсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Газрын албан хаагчдын ажлын байрандаа ая тухтай түр амрах өрөө, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор чийрэгжүүлэлтийн өрөө, халуун усанд орох өрөөг тус тус бий болгов.<br> | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Мөн албан хаагчдын бяцхан хүүхдүүдэд зориулж хүүхдийн аюулгүй, тав тухтай байх орчинг бүрдүүлсэн болно. Эдгээр орчин нөхцөлийг газрын хамт олны нэгдсэн санаачлага, санхүүгийн дэмжлэгээр бий болгосон болно.<br> | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  Урианы жилийн хүрээнд аймгийн Ажил олгогч эздын холбооноос бизнес эрхлэгчдийн дунд сургалт зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж сургалтын танхимаар үнэ төлбөргүй хангаж нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн талаар мэдээлэл хүргэж ажиллав. | |
| 4.2.2. | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | - | Дуудлага алдалт 10% ба 15%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна | Ирсэн дуудлага 1782, дуудлага алдалт дунджаар 15 %. | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч ажилласан байна. | Тайлант хугацаанд иргэд, даатгуулагч, ажил олгогчид үйлчилгээг илүү хялбар авах боломжийг бүрдүүлж, 70274004 дугаарын (callpro) дуудлагын лавлах утсанд нийт 3118 дуудлага ирснээс 97.2 хувьд нь буюу 3031 дуудлага бүрт тус газрын холбогдох байцаагч, мэргэжилтнүүд тухайн цаг үед нь хариулт өгч, асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. Харин алдагдсан 87 дуудлага алдагдсаны 56 нь даатгуулагчаас шалтгаалсан, 31 дуудлагад холбогдох байцаагч ажилтнууд даатгуулагчтай эргэн холбогдож асуудлыг шийдвэрлэсэн болно. Ирсэн дуудлага 3118, дуудлага алдалт 87 буюу 2.8%-ийг эзэлж байна. | 100 |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл | - | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл | Нийгмийн даатгалын хууль | Түүнчлэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга, үйлчилгээний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах; | | сурталчилгааг<br>-“Рийл” улиралд 3-аас доошгүй удаа;<br>-“Постер” сард 3-аас доошгүй удаа;<br>-“Видео контент” улиралд 1 удаа;<br>-Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа; | ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан. | тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна. | талаар 14 постер мэдээлэл, 3 удаагийн рийл, 1 удаа видео контент, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевизэд 8 удаагийн цаг үеийн мэдээ, мэдээллийг тус тус сурталчилж, 6 төрлийн үйлчилгээний гарын авлага хэвлүүлж, нийтдээ 2500 орчим гарын авлага, тараах материал түгээн, сургалт сурталчилгаанд ашигласан байна. Тус газар нь Нийгмийн даатгалын цахимжсан 17 төрлийн үйлчилгээг үйлчилгээг иргэд, даатгуулагчдад ажил олгогч, даатгуулагчдад сурталчлан таниулж нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай хүргэн ажиллав. | |
| ***Зорилт 4.3:*** *“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3.1. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх | | Ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, удирдамж, тайлан | 2024 онд 1 удаа зохион байгуулсан байна.<br>2024 онд 1-4 удаа зохион байгуулсан. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авсан байна. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд 2025 оны 06 дугаар сард төвийн бүсийн аймгуудын дунд зохион байгуулагдсан ижил мэргэжилтний үзлэгт зөвлөлийн 5 гишүүний бүрэлдэхүүнтэй оролцож, Орхон аймгийн магадлалын зөвлөлийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, шийдвэрлэсэн байдалд ижил мэргэжилтний үзлэг хийж үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.<br>1.Мэдээллийн баазад хяналт хийж, нас барсан 31, шилжиж явсан 11, сум хооронд шилжсэн 44, нийт 86 хүний мэдээллийг залруулж зөрүүг арилгав.<br>2.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн санг Нийгмийн даатгалын болон | 100 |
| | | | Дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд сар бүр хяналт тавьж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн байгууллагаас тэтгэвэр авагчдын бүртгэлтэй тулган шалгах ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, зөрчлийг арилгаж ажилласан байна. | халамжийн сангийн мэдээлэлтэй тулгалт хийв. Энэхүү ажлын хүрээнд ажилласан жил тооцуулан халамжийн тэтгэврээс нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрт шилжсэн 350 орчим хүний мэдээллийн зөрүүг арилгах ажил 60 хувьтай байна.<br>3.Хөдөлмөрийн чадвар алдалтын сунгалтын хугацаа дуусcанаас хойш 06 сараас дээш хугацаагаар ирээгүй 25 даатгуулагч /хүн/-ийн хөдөлмөрийн чадвар алдсан хугацааг цуцлах талаар иргэнд мэдэгдэж цуцлах арга хэмжээг авч ажиллав.<br>4.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд хөдөлмөрийн чадвар алдсан хугацааг тогтоолгохоор ирүүлсэн 40 хүний баримт бичиг, шинжилгээг нягтлан хэлэлцэж, өвчний оношийн заалтын шалгуур хангаагүй гэсэн үндэслэлээр буцаав.<br>5.Хяналтын хугацаанд эрхтэн систем нь тогтворжсон 75 даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг холбогдох шинжилгээнд үндэслэн цуцаллаа.<br>6.Тус аймгийн нутаг дэвсгэрт байрлах хорих ангид шүүхээр ял эдэлж буй тус аймгийн харьяат бус 5 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь хугацааг хэлэлцэн шийдвэрлэлээ.<br>7.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн хуралд оролцсон ирцийн мэдээлэл 97.5 хувь, өвчтэй, чөлөөтэй хугацааны эзлэх хувь 2.5 хувь, нэг иргэний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэх дундаж хугацаа 7-8 минут байна.<br>8.Өндөр насны тэтгэвэрт шилжих хүсэлт, өргөдөл-23, хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлах-1 гомдол, хүсэлтийг тус тус хүлээн авч шийдвэрлэв. | |
| 4.3.2. | Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх | | Хийсэн судалгаа, дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | - | Аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд хийсэн судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран тодорхой арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна. | Тайлант хугацаанд хийсэн судалгаа:<br>1.Төв аймгийн хэмжээн дэх нийт хөдөлмөрийн чадвар алдсан байдлыг сумдаар<br>2.Тэргүүлж буй өвчлөлийн шалтгаан<br>3.Улс аймгийн дунджаас хөдөлмөрийн чадвар алдалтын байдлын хувь шалтгаан өндөр сумдын өвчлөлийн байдлын судалгаа<br>4.Хугацаагүй сунгагдсан иргэдийн судалгаа<br>5.Гадаадад байгаа иргэдийн судалгаа<br>Хөдөлмөрийн чадвар алдсан хувь хугацааг тогтоолгосон тэтгэврийн насанд хүрсэн даатгуулагч /иргэн/-ийн судалгааг тус тус гаргаж эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтэн, 27 сумын нийгмийн даатгалын байцаагч, мэргэжилтэн нарт мэдээ, мэдээлэл хийж танилцуулав. Хяналтын эмчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтэд тусгагдсан хөдөлмөрийн чадвар алдсан иргэнийг эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх талаар тусгах, цаашид үр дүнг тооцож хамтран ажиллах агуулгатай албан бичгийг аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдлагад хүргүүлэв. Хугацаагүй сунгагдсан 540 иргэний судалгааг | 100 |
| | | | Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн хадгалалт, эмх цэгцийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан | | Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичиг /амбулаторийн карт, рентгент зураг, CD8 DVD зэрэг/-ийн эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн байна. | сумдаар гарган сумын эрүүл мэндийн байгууллагуудад албан бичгээр хүргүүлж, тайлан, мэдээг авах талаар хамтран ажиллаж байна. Үнэт цаасны тооцоогоор зарцуулсан актын маягтын тоо 720, хүчингүй актын тоо 5, актын маягтын үлдэгдэл 604, шийдвэрийн үлдэгдэл 823 байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагаатай холбоотой 5 боть баримт бичгийг архивт, хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг цуцалсан хувийн хэргийг Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус жагсаалтаар хүлээлгэн өгөв. | |
| 4.3.3. | Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах | | Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан | 2024 онд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан | Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-д орсон өөрчлөлт, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг бичиж илгээхэд гарч буй нийтлэг зөрчил, цаашид анхаарах асуудлууд, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг хугацаагүйгээр тогтоолгосон даатгуулагч /хүн/-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд сумын эмчийн үүрэг оролцоо, авлига ашиг сонирхол, ёсзүйн талаар 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр цахим сургалт зохион байгуулж нийт 24 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалт, өдөрлөг, цахим сурталчилгааны тоо, мэдээлэл авсан иргэдийн тоо, тайлан | 2024 онд 3-аас доошгүй удаагийн сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл өгсөн | Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдтэй хамтран эрүүл мэндийн магадлалын талаар ерөнхий мэдээлэл өгч, иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, сурталчилгаа хийж мэдээллээр хангасан байна. | сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн хуудас бичих эрх бүхий 98 эмчийг хамрууллаа. Мөн аймгийн нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн чадвар алдалт тогтооход оролцоо үүрэг бүхий эмч нарт авлига ашиг сонирхол, ёсзүй, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлын талаар 2025 оны 4 дүгээр сард сургалт хийж, мэдээлэл өгөв. | |
| 4.3.4. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөлмжийн хэрэгжилтийг зохион байгуулах | | Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо | 2024 онд 5 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 4 судалгаа хийж тайланг Төв зөвлөлд хүргүүлэн ажилласан | Дээд газраас өгсөн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна. | Тайлант хугацаанд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийн санал, эмнэлгийн хуудасны бичилт олголтын журамд өөрчлөлт оруулах саналын төслийг тус тус боловсруулж хугацаанд нь хүргүүлэв. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 2025 оны эхний хагас жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 21 удаа 129 цаг хуралдаж 835 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцсэн бөгөөд үүнээс 143 хүний ХЧА-ыг шинээр тогтоосон, 577 хүний ХЧА-ын хугацааг сунгасан, 75 иргэнийг ХЧА-ыг цуцалсан, 40 хүнийг буцааж шийдвэрлээд байна. Дээрх хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоолгосон иргэдээс хувь өссөн 19, хувь буурсан 21 хүнийг тус тус магадлалаа. | |
| ***Зорилт 4.4:*** *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: Зорилт 4.4:*** *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.4.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлсэн алдаатай болон даатгуулагчийн мэдээлэл дутуу оруулсан 279 тайланг цуцалж, мэдээллийг үнэн зөв болгож мэдээллийн санд оруулж ажиллав. | 100 |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | | - Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна. | Тайланд хугацаанд 933 ажил олгогч байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалган хүлээн авч баталгаажуулж ажиллалаа. Тайланд даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, тушаалын бүртгэл, даатгуулагчийн төрөл код, ажил мэргэжлийн кодыг зөрүүтэй тайлагнасан 98 аж ахуйн нэгж, байгууллагын тайланг цуцалж, засварлан үнэн зөв болгон илгээснээр мэдээллийн санд оруулж ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна. | | |
| 4.4.2. | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх; | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй тухай бүр шалган сайн дурын даатгуулагчийн гэрээг шалган бүртгэл хийж ажиллав. | 100 |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байхад анхаарч шалгаж бүртгэв. | 100 |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлэн хийхгүй буюу авлага үүсгэлгүй ажиллав. | 100 |
| 4.4.3. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах; | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | - | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд мэдээллийн шинэ систем нэвтрүүлсэнтэй холбоотой газрын албан хаагчдад албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу программд нэвтрэх эрхийг тохируулах арга хэмжээ авч, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | Газарт ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэл, шинэ системийн хөгжүүлэлтийн талаар ирүүлсэн чиглэл, зөвлөмж, зааврын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Шаардлагатай тохиолдолд үүссэн кэйс, нөхцөл байдлыг НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвд тухай бүрт хандан чиглэл, заавар, зөвлөмж авч шийдвэрлэн ажиллалаа. Мэдээлэл технологийн төвөөс зохион байгуулсан цаг үеийн шинжтэй ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь гарган хариу өгч ажиллалаа. | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Үндэсний бичгийн танхимын сургалтад хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох; | Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна.<br>-Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна. | Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна | Үндэсний бичигт хөрвүүлэх | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, газрын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Хүмүүн цогцорбор дунд сургуулийн багш Д.Отгонбаярын Монгол бичгийн анхан болон дунд шатны төлбөрт сургалтад хамрагдав.<br> | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Газрын хэмжээнд тайлант хугацаанд 49 тушаал, шийдвэр, 171 албан бичгийг 10 хувь үндэсний бичгээр зэрэгцүүлэн хөтөлж хэвшүүлсэн болно.   | |
| 2 | Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд хамрагдах; | Сургалт, зөвлөгөөнд бүрэн хамрагдсан байна. | Удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнд 2 удаа хамрагдсан. | Зохион байгуулагдсан хугацаанд | Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн зохион байгуулагдаагүй байна. | 100 |
| 3 | Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах; | Удирдлагын манлайллын ур чадварын өнөөгийн түвшингээ тодорхойлж, хувь хүний манлайлах ур чадвараа ахиулах сургалтад 1-ээс доошгүй удаа хамрагдана. | - | Тухай бүр | Жендэрийн үндэсний хорооноос цахимаар зохион байгуулсан удирдах ажилтанд зориулсан жендэрийн асуудлаарх сургалтад тус газрын дарга, хэлтсийн дарга нар болон тус газрын дэргэдэх жендэрийн тэгш байдлыг хангах орон тооны бус дэд зөвлөлийн дарга, гишүүн бүхий нэр бүхий нийт | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 6 албан хаагч хамрагдаж 2024/3051, 3084, 3091, 3259, 3348, 3076 дугаартай гэрчилгээ авлаа.<br><br>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР<br>ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО<br>Ж-1 / 2024-3051<br>ГЭРЧИЛГЭЭ<br>Сүхбаатар овогтой Орхон<br>Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалтад амжилттай хамрагдсан тул Ж-1 гэрчилгээ олгов<br>ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА<br>2025 оны 06 сарын 05<br>Мөн “Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ” сэдэвт Удирдлагын академийн 5 модульт цахим сургалтад хамрагдав. Манлайллын ур чадварын талаарх сургалтад 2025 оны 10 дугаар сард хамрагдахаар төлөвлөж байна. | |
| 4 | Компанийн засаглалын сургалтад хамрагдах; | Удирдлагын ур чадвар, эрх зүйн ойлголт, гүйцэтгэх удирдлага, хариуцлагатай ажилтан, хувь хүний талаар мэдээлэлтэй болсон байна. | - | Тухай бүр | <br>КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ<br>CERTIFICATE<br>ГЭРЧИЛГЭЭ<br>Дугаар 1030274<br>Сүхбаатар овогтой Орхон нь<br>Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн “Компанийн төлөвлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга” нарт зориулсан Компанийн засаглалын 36 цагийн сургалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгов.<br>Д.ГАНБАЯР<br>Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийн дарга<br>Н.БАТНАСАН<br>Монгол Улсын Их Сургууль Бизнесийн сургуулийн захирал<br>2025 оны 04-р сарын 14 өдөр<br>Монгол Улсын Их Сургуулийн Биенесийн сургуулийн “Компаний засаглалын 36 цагийн сургалтад 2025 оны 04 дүгээр сард хамрагдаж 1030274 дугаарын гэрчилгээ авав. | 100 |

ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА .................................................. С.ОРХОН